

БАРУУН МОНГОЛД “ХУВЬСГАЛ” АВЧИРСАН ЭРХЭМ - НАЦОВ (СИРЕН АРАБДЫНОВИЧ)

*Г.Ариунболд**

1921 онд Баруун Монгол буюу ойрадын ард түмэнд Ц.Дамбадорж, Ц.Хасбаатарын хамтаар ардын буюу илүү оновчтой хэлбэл үндэсний эрх чөлөөний хувьсгалын гэрэл гэгээг авч ирсэн анхны партизануудын нэг бол Нацов болой.

Нацов (Шойжелов) Сирен Рабдынович нь 1898 онд Буриад Монголд төржээ. БХК(б)Н-ын 1920 оны гишүүн, мөн МАХН-ын гишүүн байсан бололтой. ЗХУ-ын иргэн. Автономит Тувагийн Бүгд Найрамдах Улсын БХК(б)Н-ын ТХ-ны нарийн бичгийн даргаар ажиллаж байгаад 1938 онд баривчлагдсан. Мөн Профинтерний боловсон хүчний хэлтсийн даргаар ажиллаж байв.

“...С.Нацов нь монгол ардын нам, ардын засгийн үйл хэрэгт идэвхтэй оролцож явжээ. Түүнийг 1922 оны өвөл Ховдын сайдын яамны зөвлөхийн албанаа томилсон бөгөөд дөрвөдийн хоёр аймгийн ард түмний дотор намын суртал нэвтрүүлэг хийх давхар үүрэг хүлээж байв. Тэндээс эргэж ирээд 1924 оны 3-р сараас 6-р саруудад Монгол Ардын Хувьсгалт Намын Төв Хороонд хариуцлагатай ажил хийж байхдаа коминтерний V их хуралд Монголын төлөөлөгчдийн хамтаар оролцжээ. С.Нацов нь 1927-1930 онд олон улсын Лениний сургуулийг амжилттай суралцан төгсгөж, Коминтерний дорнод хэлтэсийн томилолтоор МАХН-ын Төв Хорооны зөвлөх сургагчийн албыг хааж байлаа.

С.Нацов нь эрдэм шинжилгээ болон нийгэм, улс төрийн талаар хэвлэн нийтлэх ажилд идэвхийлэн оролцож байжээ. Энэ үедээ Намын Төв хэвлэлүүдэд марксизм-ленинизмын үзэл санааг тайлбарласан өгүүлэл бас монгол орныг капиталист бус хөгжлийн замаар удирдах тухай онол, практикийн асуудлаар нэлээд өгүүлэл бичжээ. С.Нацов нь 1932 оноос эхлэн олон улсын Лениний сургуулийн аспирантурт суралцан 1934 онд төгсгөж, уул сургуульдаа доцентоор ажиллаж байгаад 1936 оноос Бүгд Найрамдах Тува Улсын Ардын Хувьсгалт Намын Төв Хороонд коминтерний томилолтоор 1938 оны 8-р сар хүртэл ажилласан байна.

С.Нацовын гавьяа зүтгэлийг үнэлэн Монголын засгийн газар 1922 онд “Эрдэнийн Очир” одонгоор шагнасан байна. Мөн ардын хувьсгалын 10 жилийн ойгоор 1931 онд Улсын Бага Хурлын тэргүүлэгчдийн зарлигаар, түүнийг зөвлөлт Оросын хэсэг нөхдийн хамтаар байлдааны гавьяаны улаан тугийн одонгоор шагнажээ”.¹

* Г.Ариунболд - БХИС-ийн БХЭШХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

Монголын түүхэн зүтгэлтэн, түүний дотроос Баруун Монголоос Монгол ардын хувьсгалыг дэмжин анхлан оролцсон хүмүүсийн нэгэн бол Дөрвөдийн Далай хан аймгийн Зоригт ханы хошуу буюу одоогийн Увс аймгийн Давст сумын харъяат Өлзийтийн Бадрах² нь хувь заяа, үүх түүхээрээ Нацовтой салшгүй холбогдсон гэлтэй.

1921 оноос эхэлсэн Нацов, Ө.Бадрах нарын үерхэл нөхөрлөл нь Аугаа их Октябрийн “хувьсгалт” үзэл санаан дээр үндэслэн, тэдний ажил, амьдралд гүн гүнзгий нөлөөгөө үзүүлж, намтар түүхэнд ихээхэн ул мөрөө үлдээсэн ажгуу.

Чухамхүү зохиогчийн³ “Үнэн” сонины 1991 оны ардын хувьсгалын түүхэн ойд зориулан бичсэн нэгэн өгүүлэлд Ө.Бадрахын тухай тэмдэглэсэнчилэн: “...XX зууны эхэн (20-оод он буюу тодорхой хэлбэл 1921 он - Г.А.) болоход Оросын Цагаан хааны үлдэгдэл генерал Бакич, Резухин, Кайгородовын цэргүүдийн эсрэг Ховдын хязгаарт болсон тулалдааны үеэр Улаан цэргийн партизан Байкаловын болон МАН Ардын Түр Засгийн Газрын төлөөлөгчдөд Ц.Хасбаатар, Ц.Дамбадорж, С.Нацов нар цэрэг элсүүлэн авах хийгээд уналга морь, хүнс, хэрэглэл зэргээр туслахад гар бие оролцож ирсэн түүхтэй байх ажээ...”. Энэ талаархи түүхэн баримт сэлт МАХН-ын болон Үндэсний Түүхийн Архивын сан хөмрөгт тэр бүр элбэг бус байх аж. Харин зарим сонин хэвлэлийн хуудаснаа эл үүх түүхийн хэсэг бусад зүйл ганц нэг мөр болон хадгалагдан үлдсэнийг сурвалжлан олж судлаач би вээр товч дурьдсу.

Боловсролын Их Сургуулийн багш, уран зохиол судлаач Д.Дашдорж “Улаан од” сонины 1988 оны №18(8955)-д нийтлүүлсэн “Толбо нуурынхныг тодруулахад” цуврал өгүүлэл дээ дурьдахдаа: “...Бичгээ гульнхаа уланд хийгээрэй! гээд биднийг явахад Дамбадорж (Абмал) Цагааннохой Шар Бадрах нар үдэж гаргаад малын эрэлчний маягаар болгоомжтой яваарай гэсэн”.⁴

Мөн доктор Д.Дашдулам, На.Сүхбаатар нарын зэрэг олон судлаачид Ө.Бадрахын Ц.Хасбаатар, С.Нацов, Ц.Дамбадоржийн цэрэгт хэрхэн туслаж байсан тухай нэг бус удаа товч атугай дурьдсан нь буй.

Энэ үед Ц.Хасбаатар, К.К.Байкалов нарын хамт цагаан хааны генерал Бакичийн цэрэгтэй Толбо нуурын дэргэд Саруул гүний нутагт домогт тулалдаан хийж, монгол цэргийн түүхэн дэх урт удаан хугацааны бүслэлтийг сэтлэн дайснаа ялан дийлсэн түүхийг тэмдэглэх хэрэгтэй билээ.

Чухамхүү С.Нацовыг Зөвлөлтийн талаас монголын үндэсний хувьсгалд гар бие оролцуулахаар ирүүлсэн нь, түүний дотор онц хариуцлага бүхий хэрэг явдалд илүү их оролцуулж асан нь, их л нууц бөгөөд хариуцлагатай байсан гэлтэй. Судлаач би вээр С.Нацовын цаашид ч Монголын онц хариуцлага бүхий чухал үйл явдлуудад, түүний дотор Баруун Монгол дахь хэрэг явдалд оролцож ирсэнийг онцлон анхаарах нь судлаачдын хувьд чухал болохыг тэмдэглэж байна.

Зарим нэгэн баримтаас үзэхэд С.Нацовыг Коминтерны журмаар онц чухал ажил албанд томилогдож, ажиллаж байсан чекист байхыг ч үгүйсгэх аргагүй хэмээн үздэг.

Харин Ө.Бадрахын хувьд магадгүй С.Нацов, Ц.Дамбадорж нартай Баруун Монгол дахь хувьсгалт үйл ажиллагаанд гар бие оролцож байснаас эхлэн ойр дотно танилцах болсон нь, хожим хойно чухамхүү Улаанбаатарыг зорьж, улс төр олон нийтийн олон арга хэмжээнд гар бие оролцох үүд хаалгыг нь нээж өгсөн гэлтэй. Тэрвээр⁵ “...Ховдын хязгаар Баруун Монгол даяар Ардын Түр Засгийн газар байгуулагдаж, хувьсгалт ардчилсан бодлого хэрэгжиж эхэлсэн үеэс 1921 онд МХЗЭ-д гишүүнээр элсэн, мөн бас МАН-д ч гишүүн болсон түүхтэй.

Удалгүй тэрвээр 1924 онд чухамхүү МХЗЭ-ийн шугамаар Улаанбаатар Хотын ХЗЭ-ийн төлөөлөгчийн хувиар МАН-ын III их хуралд албан ёсны бусаар оролцсоноос, анх монголын улс төрийн түүхийн тавцнаа нэр алдараа дуурсгасан байна.

Харамсалтай нь түүний намтар түүх монголын түүхнээ тийм ч эерэг мэдээгээр бус, “санамсартай, санамсаргүй нь”⁶ мэдэгдэжгүй МАН-ын дарга Солийн Данзанг үүрэгт ажлаас нь солих улс төрийн “хуйвалдаан”-д Ринчино, Ц.Дамбадорж, С.Нацов нарын шууд удирдлагаар оролцсон⁷ нь түүхэн баримтуудаас үзэхэд харагддаг билээ.

Энэ талаар дараа нь МАН-ын III их хурал дээр хэлсэн үг нь түүхэнд тэмдэглэгдэн үлдсэн байдаг юм.

Энэхүү МАН-ын III их хурал дээр МХЗЭ-ийн нийслэлийн хорооны төлөөлөл болж оролцсон эл явдал нь түүнийг Коминтерний зүгээс анх удаа чухам хэн бэ? гэдгийг шалгах сорилт шалгалт байсныг үгүйсгэх аргагүй буй заа. МАН, төрийг үндэслэн байгуулагч ахмад хувьсгалчдын (С.Данзан, Баваасан, Буяннэмэх – зох.) эсрэг Коминтерн, КИМ-ийн төлөөлөгч нарын найруулсан улс төрийн сөрөг үйл ажиллагаанд холбогдож буйгаа тэрвээр тэр бүр ухамсарлаж амжаагүй бололтой. Гэлээ гэсэн ч энэ бүхэн нь түүнийг Баруун Монгол - Ховдын хязгаарыг төлөөлөн Улсын анхдугаар их хуралд албан ёсны төлөөлөгчөөр сонгогдон оролцох хийгээд мөн Монголын улс төрийн тавцнаа гарах нэг үүд хаалгыг нээж өгсөн байж болох ажээ.

Ийнхүү Өлзийтийн Бадрах хэмээх энэ эрхмийн хувьд энэ нь тусгаар тогтноод удаагүй байсан залуу Бүгд Найрамдах Улсын буюу Монголын улс төрийн зүтгэлтэн болох анхны гараа нь болсон түүхтэй.

Магадгүй С.Нацов, Ц.Дамбадорж нарын нэр нөлөөний дор улс төрийн тавцанд гарсан тэрбээр аажим аажмаар “Коминтерний”-хэний⁸ анхаарлын төвд орсон бөгөөд улмаар шинэ тутам үүсэн байгуулагдсан залуу Бүгд Найрамдах Улсын Сангийн Хэрэг Эрхлэх Явдлын Яамны анхны (1921 оноос бол 5 дахь) сайд болсон байна.

Энэ бүхэн нь Коминтерны зүгээс шинэ тутам үүсгэн байгуулагдсан Бүгд Найрамдах Монгол Ард Улсын төр, засгийн удирдлагад зөвхөн “хөдөө”-гийнхэн буюу хөдөө орон нутаг, жирийн харц малчин ард олон түмнээс өөрийн төлөөлөлтэй болгох гэсэн зорилготой бус, мөн өөрийн талдаа үнэнчээр зүтгэх хүсэл эрмэлзэл бүхий өөрийн төлөөллийг эртнээс бэлтгэх гэсэн нэгэн алхам байсныг үгүйсгэх аргагүй. Учир нь Ө.Бадрах нь хотын эвлэлийг төлөөлөн МАН-ын III их хурал дээр өөрөө өөрийгөө Коминтерн, КИМ-ийн талд буюу “Зөвлөлт” “нийгэм журам”-ын талд орно гэдгээ илэрхийлсэн байж болох талтай билээ. Харамсалтай нь энэ бүхнийг тэр бүр баглан харуулах түүх архивын баримт сэлт учир дутагдалтай болой. Гэсэн хэдий ч, Бадрахын 1924 онд улс төрд орж ирсэн түүхэн баримт сэлт үүнийг зарим талаар нотлон харуулж буй мэт хэмээн үзэж болох талтай.

Ер нь 1921 онд Ховдын хязгаарт ардын хувьсгал ялан мандах үеэс большевик намын гишүүн С.Нацов, баруун монголын жирийн харц ард хөвгүүн Ө.Бадрах нарын нөхөрлөл эхэлсэн түүхтэй буюу. Тэдний “дотно” нөхөрлөл 1937 онд Москвад хамт улс төрийн хилс хэрэгт холбогдон баривчлагдах хүртэл үргэлжилсэн түүхтэй билээ.

Хожим хойно буюу 1939 оны 11-р сарын 20-нд МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн дарга асан Өлзийтийн Бадрахын ЗХУ-ын нийслэл Москва хотноо НКВД-д баригдаад өгсөн мэдүүлэгт: “...Тиймээ, Нацовыг би танина, түүнийг анх 1921 онд Ховд аймагт орон нутгийн засаг захиргааг байгуулахаар болон хувьсгалын эсэргүү этгээдийг цэвэрлэхээр ирэхэд харсан юм. Нацовтой илүү дотно байдлаар 1924 оны сүүлчээр танилцсан, миний бие Улаанбаатарт ажлаар шилжин очих болж, тэнд БНМАУ-ын Сангийн Явдлын Яамны сайдаар ажиллах болсон юм.

Нацов мөн 1925 оны үеэр КИМ-ын бүрэн эрхт төлөөлөгчөөр ажиллах болсон юм...” гэсэн нь буй.⁹

1921 онд ардын засаг тогтсоны дараахнаас эхлэн партизан Дэмбэрэл Шинжааныг Хятадаас салгаж, шинэ төр улс байгуулах зорилго тавин ажиллаж иржээ. Энэхүү зорилгоо хэрэгжүүлэхийн тулд тэр нэг бус удаа Шинжаан Уйгарт очиж амь дүйсэн ажил хийж иржээ. Тэрвээр Шинжаан Уйгарт Хасан Хаджиев, нутгийн монгол Наваан зэрэг тэдний төлөөлөлтэй нууц холбоо тогтоон хамтран ажиллаж ирсэн байна. Тийм нэг удаагийн аялалдаа Нацов болон Навааны хамт явж байсан тухай Шижээгийн ярьсан мэдээ буй. Нацов МАХН-ын төлөөлөгчийн хувиар Шинжаан Уйгарын Галдзай хэмээх хотод үлдэж, намын даалгаврыг нууц байдалд хэрэгжүүлж орон нутгийн монгол, уйгаруудын дунд суртал ухуулгын ажил явуулж байжээ. Энэ талаар мөн Оросын судлаачийн дурьдсан нь ч бас буй.

Ийнхүү Ө.Бадрах, З.Шижээ нарын болон Коминтерний зүгээс Шинжаан Уйгарыг чадвал Баруун Монгол буюу одоогийн Ховдын

хязгаартай нэгтгэсэн Холбооны Улс байгуулах бодлого, төлөвлөгөө, үйл ажиллагаанд оролцож байсан хүмүүсийн нэгэн бол Коминтерн, Зөвлөлтийн талаас С.Нацов байжээ.

Түүний дараа Нацов ЗХУ-д ажлаар явах болсон. 1930 оныг хүртэл Нацов ЗХУ-д байж байгаад, дараа нь БНМАУ-д эргэн ирсэн. 1930 оноос 1932 оныг хүртэл тэнд МАХН-ын ТХ-ны суртал болон ухуулгын хэлтсийн зааварлагчаар ажиллаж байсан. Мөн түүхэн цаг үе ЗХУ-д ч тэр, мөн түүний шууд хуулбарыг БНМАУ-д хэрэгжүүлэх гэж хичээж байсан Коминтернийхний оролдлогоор “зүүний” хэмээх тодотголтой “нугалаа” завхрал монгол орон даяар өрнөхөд С.Нацов ч большевик хүний хувьд БХК/б/Н-ын томилолтоор Коминтерний Монгол дахь төлөөлөгч нарын хамтаар оролцсон ба Бухаринчуудын ч, Сталинистуудын ч гар хөл болохоос өөр арга зам байгаагүй төдийгүй, үүнийгээ хятадын хувьсгалын нэгэн адил Ази дорно дахины дарлагдсан пролетари нарын нэг монголын ядуу зарц, үгээгүй малчин ардуудад тус дэм болон тэмцэж байна хэмээн өдөр, шөнийг үл хайхран суртал ухуулга хийж, МАХН-ын их, бага хийгээд ТХ-ны Бүгд хурлуудад нэг бус удаа илтгэл тавьж, сонин сэтгүүлд олон тооны өгүүлэл туурвин нийтлэж уйгагүй хөдөлмөр, цаг хүчээ зарцуулж ирсэн нь нэг талдаа монголын үндэсний хувьсгалын хувьд, “хэт ангич”, үл тохирох шинжтэй зүйл байсан боловч, нөгөөтэйгүүр, хувь хүнийх нь хувьд үзэх ахул, түүхэн цаг үеийн бүтээгдэхүүний хувьд тэр хүний “буруу” гэхэд хэцүү ажгуу. Тэрвээр МАХН-ын түүхэнд сөрөг байр суурь баримталж асан Амагаев хэмээх “большевик”-ийн хамт МАХН-ын 7-р их хурлын гол зүйлийн нэг болсон “хөдөө”-гийн бүлгийн дэвшүүлсэн гэгдэх “Зүүний эрмэлзэх саналын мөрийн хөтөлбөрийн” эх зохиогч хоёр хүний нэг байсан ажээ. Москва хотноо түүнийг ажиллаж байхад Коминтерний удирдлагаас эл түүхэн баримт бичгийн эхийг Монгол орны бодит байдлыг сайн мэдэх хүний хувьд Амагаевын хамтаар бодож боловсруулахыг түүнд даалгасан байжээ.

1930 онд МАХН-ын анхдугаар бага хурлын үеэр Бадрах, Шантанов нарын хамт Нацов намын бүтэц зохион байгуулалтын талаар илтгэл бэлтгэж, түүнийг нь Ө.Бадрах тавьсан бололтой.¹⁰

МАХН-ын ТХ-нд дотоодын хар, шар феодалуудтай тэмцэх асуудал хэлэлцэж, ялангуяа, хил орчимынхыг онцлон үзсэн байна. Энэ үед Бичээ, Полонский, Нацов нараас эдгээр феодал агсдыг Монгол орны гадаад улс төрийн байдал нэн түгшүүртэй байгааг харгалзан үзэж шоронд хорьж, баривчлан, устгах зааварчилгаа өгч байсан архивын мэдээ ч буй ажээ. Энэ зааврыг Коминтернээс ирүүлж байсан бололтой.

Ө.Бадрахын хэлснээр бол: “...Миний бие мөн үед МАХН-ын ТХ-ны хоёрдугаар нарийн бичгийн даргаар ажиллаж байсан билээ. 1932 онд Нацов Москвад ажиллахаар явж, Профинтерн буюу Үйлдвэрчний

интернационалын байгууллагад ажиллах болж, үүний хамт “Гадаадын ажилчин” хэвлэлийн газрын редакцид давхар нэгэн зэрэг ажиллаж байсан юм. 1934 онд БНМАУ-аас Москва руу шилжин ажиллах болж, Коминтерны удирдлаган дор 1935 оны нэгдүгээр сард Коминтерны шугамаар миний бие “Гадаад Хэвлэлийн” газарт ажилд орж,¹¹ монголын хэлтсийн зөвлөхөөр ажиллах болсон юм. Гадаад хэвлэлийн газар миний бие 1937 оны 12-р сарын 7-ны өдрийг хүртэл ажиллаж, арван хоёрдугаар сарын сүүлээр би (миний бие) баривчлагдсан юм...”.

“...Нацовыг МАХН дахь “зүүний”-ийг хамгаалагч хэмээн мэддэг байсан, 1930 он хийгээд дараа дараагийн жилүүдэд “зүүнтэн” нар өөрсдийн ажил явуулгадаа намын чиг шугамын эсрэг явах үед, ардуудын дунд хүчээр хамтрал байгуулж, БНМАУ-д байсан сүмүүдийг хаахын төлөө, хүн амын чинээлэг хэсэгт өндөр татвар ноогдуулахын төлөө тэмцэж байв...”

Нацов өөрийн практик ажил дээрээ МАХН-ын суртал ухуулгын хэлтсийн зааварлагчийн хувьд “зүүнтэний” нугалаатан нарын явуулж буй чиг шугамыг хамгаалахын төлөө явж байсан, үүний хамт энэ асуудлаар сонин хэвлэлд тусгай зарим нэгэн өгүүллүүд нийтлүүлж байсан...”¹² ажээ.

Ө.Бадрахын хэлснээр: “...Нацов “зүүнтэний” эрмэлзэх зүйлүүдийн мөрийн хөтөлбөрийн үүднээс үг хэлэх явдал байсан, харин ямар хурал, бага хурал гэдгийг одоо би сайн санахгүй байна. Яагаад гэвэл Нацов мөн үед суртал ухуулгын хэлтсийн зааварлагчаар ажиллаж олон ч удаа үг хэлж байсан юм...”.

Ө.Бадрах нь Москвад 1934 оны 6-р сараас 1936 оныг хүртэлхи хугацаанд Нацовтой олонтаа уулзаж байжээ. Бадрахын ярьснаар бол “...1936 оноос хойш миний бие Нацовтой тааралдсангүй...” гэжээ.

Ө.Бадрах нь Нацовтой өөрийн гэрт болон түүний гэрт ч уулзалддаг байсан нь тэр хоёр их л ойр дотны харьцаатай байсан гэх үндэстэй ажээ. Мөн түүний хамт зун цаг тэд Москвагийн (паркуудад) цэцэрлэгт хүрээлэнд уулзалддаг байсан ажээ.

БНМАУ-д байх үеийн “...Нацовын ойр дотны хүмүүсээс Лувсаншарав, МАХН-ын нарийн бичгийн дарга Шижээ, Улсын Бага Хурлын орлогч дарга Дэндэв, КИМ-ын Бүрэн Эрхт төлөөлөгч Вандано нар байлаа”.

ЗХУ-д байх үе дээ гадаад хэвлэлийн газрын монголын хэлтсийн эрхлэгч Балданотой¹³ ойр дотны харилцаатай байсан ажээ. Энэхүү мөрдөн байцаалтын үеэр чухамхүү С.Нацов, Ө.Бадрах нарыг Москва хот дахь улс төрийн онц хүнд хэрэгтнүүдийг хорьдог Лефортово шоронд хорьж байгаад, нүүрэлдүүлэн байцаасан байх юм. Аль аль нь чухам энэ шоронд байцаагдан хоригдож байгаад цаазаар авахуулсан бололтой.

С.Нацовын талаархи ОХУ-ын улс төрийн хилс хэрэгт хэлмэгсдийн судалгааны “Мемориал” сангийн фонд дахь каталогт бүхий баримтаас үзэх ахул: “...Коминтерны Дорно дахины нарийн бичгийн дарга нарын

газар Зөвлөлтийн эсрэг баруун - троцкист байгууллагын идэвхитэй гишүүн, японы тагнуул хийж байсан хэмээн гүтгэгдэж, Улс төрийн хил хэрэгт хэлмэгдэн өртөж ЗСБНХОУ-ын Эрүүгийн хуулийн 58-ын 1-ын “а”, 58-ын 11-ээр зүйлээр яллагдаж цаазаар авахуулжээ. 1930 панмонголын нууц байгууллагын удирдлагад ажиллаж, троцкист болон панмонголын байгууллагуудын хооронд харилцаа тогтооход үүрэг гүйцэтгэсэн хэмээн сэжиглэгдэж байсан. Японы тагнуулын хувьд ЗХУ-тай холбогдох цэрэг, эдийн засаг болон улс төрийн чанартай тагнуулын мэдээг японы тагнуулын байгууллагад дамжуулдаг байсан...” хэмээн НКВД-гийн мөрдөн байцаалтын¹⁴ баримтад бичсэн нь буй.

Түүнийг Ванданов, Ринчино,¹⁵ Тубянский (шийтгэгдсэн), З.Шижээ,¹⁶ Ө.Бадрах, Лувсаншарав¹⁷ (баривчлагдсан) нартай Лефортовын мөрдөнд нүүрэлдүүлж, тэдний зохиомол мэдүүлгүүдээр батламжуулж, зохиомол хэрэг бүрдүүлсэн байх ажээ.

Ийм учир ялын дүгнэлтэд бичих дээ: “...БНМАУ-д Японы протекторат дор хөрөнгөтний феодалын төрт улсыг сэргээн байгуулах зорилгоор зэвсэгт бослогын замаар төрийн эргэлт хийх бэлтгэл ажилд оролцон, ЗХУ-тай харьцаагаа таслах зорилготой байсан...” гэжээ.

Нацов (Сирен Арабдынович буюу Шойжелов) хэмээх түүхэн хувь хүний тухай бэсрэг өгүүлэлээ үүгээр төгсгөж буй ч энэ хүний талаархи түүхэн баримт үүгээр хязгаарлагдахгүй нь ойлгомжтой.

Маш нууц

Өөрт нь.

Нөхөр Хинчукт¹⁸

Хүндэт Лев Михайлович¹⁹

Харамсалтай нь, өвдсөн минь, Танд, миний хоёрдугаар сарын 21-нд илгээсэн нөхөр Нацовын захидлын талаар дүгнэлт гаргахад саад тотгор болсон болов уу.

Одоо Амагаевыг Москва руу явахтай холбогдуулан бид дахин нэг удаа Нацовын урьдчилсан саналуудыг эргэн үзсэн бөгөөд, миний хүсэлтээр нөхөр Амагаев хөдөөгийнхний эдийн засгийн бодлогын салбарт дэвшүүлэн тавих эрмэлзэх зүйлүүдийн хөтөлбөрийн шинэ төслийн эх нооргийг боловсруулсан байна.

Энэ төсөл нь нөхөр Амагаевынх бөгөөд миний үзэж буйгаар бол Монголын дэд комиссын эцсийн хувилбараар авч үзэх шаардлагатай тийм баримт бичиг мөн. Гуравдугаар сарын 5-наас, даваа гаригаас хойшгүй, туунтэй танилцаж, өөрийн саналыг ирүүлнэ уу.

Коммунист ёсоор мэндчилсэн /С.Райт./

1928 оны гуравдугаар сарын 3.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Д.Дашдорж., “Толбо нуурынхныг тодруулахад” ., “Улаан од” ., 1988.И.10.,N•12 (8949)
2. Ө.Бадрах – МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн дарга (1928-1932 он) асан – Г.А.
3. Г.Ариунболд “Гуравдугаар хороон дарга” ., “Үнэн” сонины 1991 оны 7 –р сарын дугаар.
4. Д.Дашдорж., “Толбо нуурынхныг тодруулахад” ., “Улаан од” ., 1988.И.10.,N•12 (8955)
5. Ө.Бадрах – Г.А.
6. Түүхийн ухааны доктор Д.Дашдуламын диссертацид дурьдсан нь буй – Г.А.
7. “хэл амаараа” үг хэлж оролцсон – Г.А.
8. Ринчино, Рыскулов нарын гэх мэт – Г.А.
9. “Дело Ульзуйто Бадреха” ., Специальный Архив ФСБ Российской Федерации., Москва.(1937-1941 гг.).
10. Учир нь намын түүхэн баримтад “Нацок” хэмээн оросоор бичсэнийг Нацагдорж гэхээсээ илүүтэй Нацов боловуу хэмээн үзэж байна... – зох.
11. Ө.Бадрахыг Москвад тодорхой хугацаагаар (1934-1937онд) МАХН-ын ТХ-ны шийдвэрээр улс төрийн хилс “Лхүмбийн” гэгдэх хэрэгт Москвад цөлөгдөж байх үед С.Нацов хуучны дотны анд нөхрийн ёсоор туслаж, Коминтерний “Гадаад Ажилчин” хэвлэлийн газарт зөвлөхөөр томилсон бололтой – Г.А.
12. 1930-1932 онуудад ажээ – зох.
13. Балдано гэдэг нь Коминтернд Ө.Бадрах, З.Шижээ, С.Нацов нартай ойр дотно ажиллаж байсан бөгөөд хожим Лефортово дахь улс төрийн гянданд тэдний хэргийг мөрдөн байцаах үеэр НКВД-гийн орчуулагчаар ажиллаж байсан байх юм – Г.А.
14. ОХУ-ын улс төрийн хэлмэгсдийн “Мемориал” сангийн архивын баримт – зох. 315 дахь тал.- Г.А.
15. Ринчино – Монголд 1921-1925 оныг хүртэл удирдах албанд ажиллаж асан – Г.А.
16. З.Шижээ – МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн дарга (1930-1932 онд) асан – Г.А.
17. Лувсаншарав – МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн дарга (1932, 1939 онд) асан – Г.А..
18. С.Нацов, Амагаев нарын боловсруулсан “Хөдөөгийн бүлгийн эрмэлзэх саналыг” төслийн эхний хувилбараар Коминтерний удирдлагын ажилтнууд уншин танилцаж байсан талаархи түүх архивын нэгэн баримт – Г.А.
19. РГАСПИ буюу ОХУ-ын нийгэм улс төрийн түүхийн төрийн архив – Г.А.